



## НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

### Зардал гаргах тухай

Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хууль, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг даргын 2013 – 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг үндэслэн Монголын өсвөрийн залуу тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, биеийн тамир, спортын төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор ТУШААХ нь:

1. Хэт холын марафон гүйлтийн нэг тамирчны Катар улсын Доха хотод болох Хэт холын марафон гүйлтийн /100 км-ийн/ Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол улсаа төлөөлөн анх удаа оролцох замын, зочид буудал, хоолны зардлыг олгож дэмжлэг үзүүлсүгэй.

2. Хэт холын марафон гүйлтийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох нэг тамирчны замын, зочид буудал, хоолны зардлыг хавсралтаар баталсугай.

3. Нэг тамирчны тэмцээнд оролцоход шаардагдах зардлын 3.437.300 (гурван сая дөрвөн зуун гучин долоон мянга гурван зуу) төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын орон нутгийн төсөв /тусгай шилжүүлэг/-ийн арга хэмжээний оюутны шигшээ багийн зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон дүн мэдээ болон санхүүгийн холбогдох тооцоо тайланг 2014 оны 12 дугаар сарын 01-ний дотор гаргаж тайлагнахыг дасгалжуулагч Б.Өнөрбаярт үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД

1150500153